

**ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ, БАРИЛГА УГСРАЛТ, ХУДАЛДАА
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ “ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ” ХУВЬЦААТ КОМПАНИЙН
ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ТОГТООЛ**

2026 оны 03 –р сарын 20 –ны өдөр

№ 02

Мөрөн хот

*Хувьцаа эзэмшигчдийн ээлжит
хурал хуралдуулах тухай*

Геологи уул уурхай, барилга угсралт, худалдаа үйлчилгээний “Хөвсгөл Геологи” ХК –ийн Төлөөлөн Удирдах Зөвлөлийн хурлаас хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал зарлан хуралдуулах тухай асуудлаар хэлэлцэж, олонхийн саналыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Геологи уул уурхай, барилга угсралт, худалдаа үйлчилгээний “Хөвсгөл Геологи” ХК –ийн Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг 2026 оны 04 –р сарын 29 –ний өдрийн 10:00 цагт “Хөвсгөл Геологи” ХК –ийн хурлийн танхимд зарлан хуралдуулсугай.
2. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлаар дараах асуудлуудыг хэлэлцүүлэхээр оруулсугай.
 - Компанийн 2025 оны жилийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус Аудитын дүгнэлт
 - Компанийн 2025 оны бизнес үйл ажиллагааны тайлан
 - Компанийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
 - Компанийн дүрэм шинэчлэн батлах
 - Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
 - ТУЗ, гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох хувьцаа эзэмшигчдийн нэрсийн жагсаалт гаргах бүртгэлийн өдрийг 2026 оны 04 –р сарын 9 –ны өдрөөр тогтоосугай.
- Компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралыг хуралдуулах шийдвэр гарсантай холбогдуулан хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдэд хурлын зарыг хүргэхээр 2026 оны 03 –р сарын 24 –ны дотор өдөр тутмын сонин болон хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэх. Энэ мэдээллийг дээрх хэлбэр шаардлагын дагуу анх мэдээлсэн өдрөөс хойш 15 хоногийн дараа дахин мэдээллэхийг хурал зохион байгуулах комисст даалгасугай.
- Ээлжит хурлыг хуралдуулахтай холбогдуулан хурлын дэгийг 01 –р хавсралтаар, хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчид нь энэхүү шийдвэрийн 02 –р хавсралтанд заасан бичиг баримтыг ажлын өдрүүдэд 10.00-17:00 цагийн хооронд “Хөвсгөл Геологи”

ХК –ийн байранд ТУЗ –ийн нарийн бичгийн дарга /Б.Түмэн-Өлзий/ -с авч танилцах эрхтэй болохыг дурьдсугай.

- Тус компанийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хуралд оролцох эрх бүхий хувьцаа эзэмшигчдээс хэлэлцэх асуудлаар санал авах саналын хуудсын агуулгыг 03 –р хавсралтаар баталсугай.
- Хувьцаа эзэмшигчээс “Санал авах хуудс” –ыг хүлээн авах сүүлийн өдрийг харьяалагдах брокер, диллерийн компаниар нь дамжуулан 2026 оны 04 дүгээр сарын 24 -ний өдрөөс өмнө байхаар тогтоосугай.
- Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлыг удирдах хурлын даргаар ТУЗ –ийн дарга Л.Дашцэрэн, тооллогын комиссын даргаар Х.Эрдэнэбилэг, гишүүдээр Ч.Мөнхтулга, Ж.Цолмонбаатар нарыг тус тус томилсугай.

ТӨЛӨӨЛӨН УДИРДАХ ЗӨВЛӨЛИЙН ДАРГА



Л.ДАШЦЭРЭН

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны
03 дугаар сарын 20 –ны өдрийн
02 дугаар тогтоолын “Хавсралт-01”



**ГЕОЛОГИ, УУЛ УУРХАЙ БАРИЛГА УГСРАЛТ, ХУДАЛДАА
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ “ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ” ХК –ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ДЭГ**

1. Хурлын ирцийг бүртгэх 10:00-10:30
2. Хурлын ирцийг мэдээлэх 2 минут
3. Хурлын дарга хурлыг нээх, хурлаар хэлэлцэх асуудлууд болон хурлын дэгийг танилцуулах 5 минут
4. Хурлаар хэлэлцэх асуудлуудыг дарааллын дагуу танилцуулах, санал авах 45 минут
5. Хурлын завсарлага 10 минут
6. Тооллогын комисс тогтоолыг танилцуулах 5 минут
7. Хурлаас гарах шийдвэр, тогтоолыг танилцуулах 10 минут
8. Хурлыг хаах (хурлын дарга) 5 минут

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны
03 дугаар сарын 20-ны өдрийн
02 дугаар тогтоолын "Хавсралт-02"



**ГЕОЛОГИ УУЛ УУРХАЙ, БАРИЛГА УГСРАЛТ, ХУДАЛДАА
ҮЙЛЧИЛГЭЭНИЙ “ХӨВСГӨЛ ГЕОЛОГИ” ХК-ИЙН ХУВЬЦАА
ЭЗЭМШИГЧДИЙН ЭЭЛЖИТ ХУРЛЫН ТАНИЛЦАЖ БОЛОХ
БАРИМТ БИЧГИЙН ЖАГСААЛТ**

1. Компанийн 2025 оны жилийн санхүүгийн тайлан түүнд хийгдсэн хараат бус
Аудитын дүгнэлт
2. Компанийн 2025 оны бизнес үйл ажиллагааны тайлан
3. Компанийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөө
4. Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга
5. ТУЗ, гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв

Төлөөлөн удирдах зөвлөлийн 2026 оны
03 дугаар сарын 20 -ны өдрийн
02 дугаар тогтоолын "Хөвсгөл-03"



**“Хөвсгөл Геологи” ХКомпанийн хувьцаа эзэмшигчдийн
ээлжит хуралд санал авах хуудас**

1. Хурал хуралдах хугацаа: 2026 оны 04 –р сарын 29 –ны 10:00 цагт
2. Хувьцаа эзэмшигчийн овог нэр
3. Эзэмшиж байгаа хувьцааны тоо ширхэг
4. Хувьцаа эзэмшигчийн регистрийн дугаар:
5. Харьяалагдах үнэт цаасны компанийн нэр:
6. Хувьцаа эзэмшигчийн гарын үсэг:

Та шийдвэрийг зөвшөөрч байвал “тийм”, татгалзаж байвал “үгүй” гэж бичнэ үү

№	Хурлаас гарах шийдвэрийн товч утга	Зөвшөөрсөн	Татгалзсан
1	Компанийн 2025 оны жилийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус аудитын дүгнэлт		
2	Компанийн 2025 оны үйл ажиллагааны тайлан		
3	Компанийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах		
4	Компанийн дүрмийн шинэчилсэн найруулга		
5	ТУЗ -ийн гишүүд сонгох		
6	ТУЗ болон Гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв		

САНАЛ АВАХ ХУУДСЫГ АШИГЛАХ САНАМЖ

1. Хувьцаа эзэмшигч нь өөрийн биеэр хуралд оролцож чадахгүй бол Зуучлагч брокерийн пүүс дээр очиж хурлын материалтай танилцаад санал авах хуудсаар саналаа өгнө.
2. Засварласан болон балласан, залруулгатай санал авах хуудас нь хүчингүйд тооцогдоно.
3. Хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурлын талаарх мэдээллийг 99106457 утсаар лавлаж болно.

Санал авах хуудас хүчингүй болгосон тухай шалтгаан.....

**Өдөр тутмын хэвлэлд өгсөн
хувьцаа эзэмшигчийн хурлын зар**



**“Хөвсгөл Геологи” ХК –ийн хувьцаа
эзэмшигчдийн анхааралд**

Геологи уул, уурхай, барилга угсралт, худалдаа үйлчилгээний “Хөвсгөл Геологи” ХК –ийн хувьцаа эзэмшигчдийн ээлжит хурал 2026 оны 4 дүгээр сарын 29 –ний өдөр 10:00 цагт “Хөвсгөл Геологи” ХК –ийн Хурлын танхимд болно.

Хаяг: Хөвсгөл аймаг. Мөрөн сум. 8-р баг. “Хөвсгөл Геологи” ХК –ийн байр.

Хуралд оролцох эрхтэй хувьцаа эзэмшигчдийг бүртгэх өдөр: 2026.04.09

Хурлаар хэлэлцэх асуудлууд:

- Компанийн 2025 оны жилийн санхүүгийн тайлан, түүнд хийгдсэн хараат бус Аудитын дүгнэлт
- Компанийн 2025 оны бизнес үйл ажиллагааны тайлан
- Компанийн 2026 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг батлах
- Компанийн дүрэм шинэчлэн батлах
- Төлөөлөн удирдах зөвлөлийн гишүүдийг сонгох
- ТУЗ, гүйцэтгэх удирдлагын зардлын төсөв

Хурлын материал, гарах шийдвэрийн төсөл болон холбогдох баримт бичигтэй ажлын өдрүүдэд 10:00-17:00 цагийн хооронд “Хөвсгөл Геологи” ХК –ийн байранд ТУЗ –ийн нарийн бичгийн дарга /Б.Түмэн-Өлзий/ - с танилцах боломжтой

Холбоо барих: ТУЗ –ийн нарийн бичгийн дарга Б.Түмэн-Өлзий

Утас: 99106457